

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын
2021 оны 10 дугаар сарын үйл ажиллагааны тайлан

2021 оны 10 дугаар сарын 24-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Аравдугаарсард 305 албан бичиг бүртгэгдсэн байна. Үүнээс хариутай албан бичиг 33 ирсэн бөгөөд холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. Удирдлагын баримт бичгийн хувьд сумын Засаг даргын “А” захирамж – 151 батлагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Нийт ирүүлсэн өргөдөл 27, үүнээс ажлын байр хүссэн-3, малжуулах төсөлд хамрагдахыг хүссэн-1 байна.

2021 оны 10 дугаар сарын байдлаар шинээр төрсөн -43, үүнээс эрэгтэй – 24, эмэгтэй-19, овог, нэр өөрчилсний бүртгэл-2, нас баралт-17 /эрэгтэй-10, эмэгтэй -7/, цахим иргэний үнэмлэх шинээр захиалсан-21, цахим иргэний үнэмлэх сунгалт хийлгэсэн– 25, 45 насны- 55 тус тус бүртгэгдсэн байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Орон нутгийн төсвийн байгууллагад аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас батлагдсан удирдамжын дагуу Засаг даргын тамгын газар, ИТХ, Соёлын төвийн байгууллагуудын үйл ажиллагаанд Дотоод аудит хийж байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн шалгалтыг 20 гаруй хоног хийлээ.Үүнд:

- Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшилийг үнэлж дүгнэж зөвлөмж өгөх
- 2019, 2020 оны төсөв санхүү, үйл ажиллагаанд дотоод аудит хийх
- Төсвийн тогтвортой байдал, санхүү, төсвийн удирдлага, ил тод байдлыг хангасан эсэхэд дотоод аудит хийх
- Албан хэрэг хөтлөлт

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага болон Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн 2019-2020 оны үйл ажиллагааны санхүүгийн баримтанд хяналт шалгалт хийж шалгалтаар гарсан зөрчил дутагдлыг арилгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд чиглэгдлээ.

Хөрөнгө оруулалт, ХАА-ны талаар.

- Чийрэгжүүлэлтийн танхим байгуулах тендерийг зарлаж 35,0 сая төгрөгөөр Санаа мед трейд ХХК шалгарч байраа зассан.
- Жавхлантын багт 1500 м ЦДАШ-ын тендерийг 2 удаа зарлаж нэгч компани ороогүй тул дахин зарлаж Орон нутгаас 15,0 сая төгрөгийг олгохоор шийдвэрлэж Анарзоне ХХК шалгарсан.
- Сургуулийн дотуур байр шинээр ашиглалтанд орж цэвэр усныг 10,0 сая төгрөгөөр хийх гэрээ байгуулан ажиллаж байна.
- Соёлын төвийн барилга баригдаж байгаатай холбогдуулан дулааны холболт Одкон холдинг ХХК-д холбогдож уурын зуухыг хийлгүүлэх саналыг тавиад байна.

- Цэцэрлэгийн хүүхдийн зөөлөн эдлэл бүрэн шинэчлэлтийг 10,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэх зардлыг ЗД-ын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гаргасан.
- ЗДТГ-ын ажилчдын ажиллах нөхцөл бололцоог хангаж 2 нөтбүүк, 1 процеср, 1 принтер зэрэг 5,0 сая төгрөгийг хөрөнгийг засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас шийдвэрлэв.

Бусад ажил

Төсөвт байгууллагуудын 3-р улирлын Санхүүгийн тайланг хийж Э тайланг тушаасан. ААНБ-уудын 3-р улирлын тайланг цахимаар тушаасан.

Жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр улсын хэмжээнд 13-р байранд орж ТА-3 төслөөс урамшуулалын болзолыг хангасан.

Санхүүгийн нэгдсэн системд бүх төсөв байгууллагуудын дансыг байршуулж 1,2-р гарын үсгийн баталгаа болон холбогдох бичиг баримтыг оруулж эрхийн баталгааг үүсгэсэн.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Газар зохион байгуулалтын чиглэлээр:

Шинээр газар авах хүсэлтэй иргэдийн өргөдлийг хүлээн авч, шийдвэрлэлтийн явц, үр дүнг иргэдэд мэдээллэсэн. Шинээр газар өмчлөх 38 иргэн өргөдөл ирүүлснээс 32 иргэний өргөдлийг шийдвэрлэсэн. Газрын харилцаа цахимд шилжиж буйтай холбогдуулан “Уулбаян сумын газрын зөвлөгөө, мэдээлэл” нэртэй цахим хуудас нээн, иргэдэд мэдээллийг тогтмол хүргэж ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сүхбаатар аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газраас мал сүрэгт үзлэг ангилалт хийх ажлыг шуурхай зохион байгуулан ангилалт бүртгэлжүүлэлтэнд хамрагдсан малчин өрх, малын мэдээллийг “Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д оруулан тайланг 2021 оны 11 сарын 01-ны дотор явуулах 1/107 дугаар захирамжийн дагуу ажилласан. Үүнд:

1. Баян багийн малчин Б.Мөнхжаргал, Эрдэнэбаяр нарын хуц, ухнын сууринд 2021 оны 09 дүгээр сарын 23,24-ны өдрүүдэд 114 ухна, 190 хуцыг ээмэглэх ажлыг Хөдөө аж ахуйн бэлчээр газар тариалан эрхэлсэн мэргэжилтэн Т.Ренчин, Баян багийн засаг дарга Г.Гэрэлболд, Тэгш багийн засаг дарга Содномжамц, Дэлгэр багийн засаг дарга Э.Нандинцэцэг, ЗДТГ-н галч Б.Эрдэнэсүх нартай хамт хийж гүйцэтгэсэн.
2. Жавхлант багийн малчин Ц.Батсайхан, Д.Баасансүрэн нарын хуц, ухнын сууринд мөн Дэлгэр багийн малчин Г.Шижирбаатарын хуц, ухны сууринд 2021 оны 09 сарын 28-ны өдөр 56 ухна, 105 хуцыг ээмэглэх ангилах ажлыг Хөдөө аж ахуйн бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн Т.Ренчин, Баян багийн засаг дарга Г.Гэрэлболд, Тэгш багийн засаг дарга Содномжамц, Жавхлант багийн засаг дарга Г.Ганчимэг, ЗДТГ-н галч Б.Эрдэнэсүх, Болдбаатар нартай хамт хийж гүйцэтгэсэн.
3. Баян багийн малчин Г. Баяраа, А.Эрдэнэдэлгэр нарын хуц, ухнын сууринд 2021 оны 10 дугаар сарын 01-ны өдөр 98 ухна, 200 хуцыг ээмэглэх ангилах ажлыг Хөдөө аж ахуйн бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн Т.Ренчин, Баян багийн засаг дарга Г.Гэрэлболд нарын хамт Үхэр- Уяа мал эмнэлэгтэй хамран хийж гүйцэтгэсэн.

4. Тэгш багийн малчин Т.Шагдар, Р.Эрдэнэцогт, Э. Баттүшиг нарын хуц, ухнын сууринд 2021 оны 10 сарын 06,07-ны өдөр 145 ухна, 214 хуцыг ээмэглэх ангилах ажлыг Хөдөө аж ахуйн бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн Т.Ренчин, Тэгш багийн засаг дарга Ш.Содномжамц, Жавхлант багийн засаг дарга Г.Ганчимэг, ЗДТГ-н галч Болдбаатар нартай хамт хийж гүйцэтгэсэн.
5. Жаргалант багийн малчин Б.Самбуу, Ш.Эрдэнэдэлгэр нарын хуц, ухнын сууринд 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдөр 50 ухна, 100 хуц ээмэглэх ангилах ажлыг Баян багийн засаг дарга Г.Гэрэлболд, Тэгш багийн засаг дарга Содномжамц, Жаргалант багийн засаг дарга Г.Гүнсэн, Жавхлант багийн засаг дарга Г.Ганчимэг, Дэлгэр багийн засаг дарга Э.Нандинцэцэг, ЗДТГ-н галч Болдбаатар нар хийж гүйцэтгэсэн.
6. Баян багийн малчин Л.Ганцоож-н үржлийн малыг ээмэглэх ангилах ажлын хүрээнд 2021 оны 10 дугаар сарын 22,23-ны өдөр 18 үнээ, 116 ямаа, 225 хонийг ээмэглэх ангилах ажлыг Хөдөө аж ахуйн бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн Т.Ренчин, Баян багийн засаг дарга Г.Гэрэлболд, Жаргалант багийн засаг дарга Г.Гүнсэн, Тэгш багийн засаг дарга Ш.Содномжамц нарын хамт хийж гүйцэтгэсэн.

Сүхбаатар аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт зохион байгуулагдсан Өвөлжилт, хаваржилт цаг үеийн зарим асуудлын талаарх уулзалт сургалтанд 2021 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр хамрагдсан.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд төлөвлөгөө гаргав. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас өөрт хамааралтай бүх ажлуудыг хийж дуусгав. Тоон мэдээллүүд дээр үндэслэн зохих албан тушаалтнуудад зөвлөгөө өгч, яаралтай авч хэрэгжүүлэх ажлын санал хүргүүлэв. Хавсралтыг экселийн файлаар хавсаргав. Тоон мэдээллүүд шинэчлэгдэв.

Аймгийн мэргэжлийн хяналтын газрын Ургамал хорио цээрийн байцаагч Н.Соёлцэцэгийн зөвлөгөөг ажил хэрэг болгож газар тариалан эрхэлдэг 2 иргэнд хүнсний ногооны 6-н зүйл тус бүр дээр гарал үүслийн гэрчилгээ олгов. Бусад газар тариалан эрхэлдэг иргэд, аж ахуй нэгжүүдэд мэдээлэл өгөв.

Үржлийн малыг ангилан ялгах бүртгэлжүүлэн цөм сүрэг бүрдүүлэх ажлын амжилттай зохион байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар сумын нийт хээлтүүлэгч малаас ухна, хуцыг бүрэн ангилан ялган бүртгэлжүүлээд байна. Үүнд ухна- 556 тоо толгой, хуц-1084 тоо толгой

ХАА-10 мэдээг тогтмол илгээж байна. Сумын хэмээнд төмс- 4,1тн, лууван 0,6 тн, сонгино- 1,2 тн, өргөст хэмх- 2,4 тн, улаан лооль- 0,43 тн тус хураагдаад байна. Ургац хураалтын ажил бүрэн дуусаад байна.

Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаанд хүнсний ногоо, гар урлалын чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 4-н иргэнийг амжилттай оролцуулж 2 сая төгрөгний борлуулалт хийхэд туслаад байна.

Хүнс, худалдаа, үйлчилгээ чиглэлээр:

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит нөөцийн судалгаа 2021 оны 10 сарын 20-ны байдлаар.

Хүнсний нөөцийн мэдээг ХХААГ-т долоо хоногийн Даваа, гарагт хүргүүлдэг.

Бүтээгдэхүүний нэр	Нөөц
--------------------	------

Гурил	10 тн
Гурилан бүтээгдэхүүн	250 ш
Будаа	565 кг
Хуурай/Шингэн сүү	200 ш
Өндөг	350 ш
Ургамлын тос	203 ш
Төмс	180 кг
Хүнсний ногоо	111 кг
Элсэн чихэр	190 кг
Давс	200 кг
Савласан ус	310 ш

Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөц болон татан авалтын хомсдол үүсээгүй, тээвэрлэлт хэвийн явагдаж байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтын горим, түргэн гэмтэж чанар байдлаа алдах, хүнсний бүтээгдэхүүнийг техникийн зохицуулалтад заагдсан горимд хадгалж байгаад хяналт тавин хоол хүнсээр, дамжих өвчин, хордлого, халдвараас урьдчилан сэргийлэх, зорилгоор мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, зөвлөгөөг тогтмол хүргэн ажиллаж байна.

1.2. Шатахуун түлшний нөөцийн хувьд хэвийн хомсдол үүсээгүй.

№	Байгууллагын нэр	A-80	A-92	ДЗ
1	“Байшинт Ойл” ХХК	1тн 300	1тн 600	4 тн
2	Үнэ	2260 төг	2300 төг	2700 төг

1.3. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн судалгааг 9-10 сартай харьцуулан харуулав.

№	Бүтээгдэхүүний нэр		2021 оны 9 сарын 20 байдлаар	2021 оны 10 сарын 21 ны байдлаар
1	гурил	Дорнод дээд	36000	36000
		УБ 1-р зэрэг	37000	36000-37000
		Дорнод 2-р зэрэг	29500	29500
2	Цагаан будаа		2700-3000	2800-3000
3	Шингэн сүү		3500-3700	3500-3800
4	Хуурай сүү		5000-10500	6000-12000
5	Элсэн чихэр		2500-2800	2700-3000
6	Ургамлын тос		4800-5500	6300-6500
7	Өндөг		550-700	600
8	Төмс		1500	1000-1200
9	Хүнсний ногоо	Сонгино	3000	3000-3500
		Байцаа	2500-3000	1800-2000
		Лууван	2200	2500
		Сармис	2500	2500

10	Давс	1000-1500	1000-2800
11	Савласан ус	800-3500	900-4000

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний зохиомол үнийн хомсдол үүсээгүй байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хадгалалт, түгээлт, тээвэрлэлт, хоол үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулан, зөрчил дутагдлыг зогсоох үүрэг даалгаварыг авч, хэрэгжүүлэн зөвлөн туслах үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

2021 оны 10 сарын 01-ны өдрөөс эхлэн хүнс худалдаа, хоол үйлдвэр үйлчилгээ эрхэлдэг 9 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд 7 хоногийн 2,4 дэх өдрүүдэд тогтмол хяналт шалгалт хийж, мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн чиглэл, хавсралт хүснэгтийн дагуу зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч ажиллаж байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 10 сарын 07-ны өдөр сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Гүн хүсэл”, “Хөшөөтийн нам” ХХК, нэр бүхий, аж ахуйн нэгжүүдэд “Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Т.Амарбат хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Төрийн хяналт шалгалтын тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Хог хаягдлын тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн эрх бүхий, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгч, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт шалгалтыг явуулсан.

Засаг даргын 2021 оны 10 сарын 01-ны өдрийн А/139 дугаар захирамжийн дагуу дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллалаа.

Хэсэгчилсэн хорио цээрийн дэглэмийн хугацаанд архи согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглосон учир тусгай зөвшөөрөлтэй 5 аж ахуй нэгжийн бүтээгдэхүүнийг лацдах арга хэмжээг Хууль эрх зүйн мэргэжилтэн Л. Дашбалжиннямтай хамтран явуулсан.

- Тусгай зөвшөөрөлтэй 5 аж ахуйн нэгжийн нийт 813 ширхэг бүтээгдэхүүнийг лацадсан.

10 сарын 08.09-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Намрын ногоон өдрүүд Сүхбаатарт үйлдвэрлэв- 2021” үзэсгэлэн худалдаанд хувиараа жижиг дунд бизнес эрхэлдэг 3 иргэн оролцсон. Үүнд

- Эсгий эдлэлээр бүтээгдэхүүн хийдэг: Б.Дэнсмаа
- Хүнсний ногоо газар тариалан эрхэлдэг: Ч.Батбаяр
- Хүнсний ногоо газар тариалан эрхэлдэг: Ц.Цэгмид

Үзэсгэлэн худалдаанд “Шилдэг өрхийн үйлдвэрлэгч” номинацад Ч. Батбаяр тэргүүн байр эзэлж амжилттай оролцсон.

ЗДТГазрын Хөгжлийн бодлогын хэлтэс, Хүнс хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжилзүйн хэлтэс хамтран. Сумдын худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, сумдын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарыг чадавхжуулж сумдын тохирлын баталгаа аюулгүй байдал, эрүүл ахуйн зохистой зөв дадлыг хангасан орон нутгийн дотоодын бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх талаар зохион байгуулсан сургалтад хамрагдсан.

Монгол улсад орчин цагийн худалдааны салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойн “Төр хувийн хэвшил түншлэлийн хөгжил” форум уулзалтанд бизнес эрхлэгчдийн төлөөлөн болон 2 иргэн оролцсон.

Сум хөгжүүлэх сангийн чиглэлээр:

2021.10.22-ны байдлаар 2011-2020 оны хооронд зээл авсан 30 зээлдэгчийн 252,800,000 төгрөгийн зээл олгосон байна. Бодогдсон хүү нь 13,627,342 төгрөг. Үүнээс, зээлийн хүү, алданги ороод 115,442,314 төгрөг эргэн төлөгдсөн. Нийт үлдэгдэл 146.625.028 сая төгрөг байна.

Зээлийн хэлбэр	Зээлдэгч	Зээлийн дүн
Хэвийн зээл	10 зээлдэгч	70,000,000
Эргэлзээтэй зээлтэй	/181-360хоног/ 5 зээлдэгч	47,000.000
Муу буюу чанаргүй зээлтэй	/360≥/ - 15 зээлдэгч	131,800,000
Хаагдсан зээл	7 зээлдэгч	48,287,470,

- 9 дүгээр сарын 30-ны байдлаар зээлийн эргэн төлөлтөөр 1,42,850 төгрөг сум хөгжүүлэх сангийн дансанд эргэн төлөгдсөн байна.

2.1.2. Эргэн төлөлт хийхгүй байгаа зээлдэгч:

Зээл авсан он		Зээлдэгч	Зээлийн дүн
1	2019.05.25	Л.Мөнхнаст	9,000,000
2	2020.05.27	Э.Эрдэнэтуяа	5,000,000
3	2019.05.25	С. Эрдэнэбат	6,000,000
4	2020.05.27	Т.Чулуун	15,000,000
5	2020.05.27	Ч.Цогзолмаа	6,500,000

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэх 1 зээлдэгч:

С. Шарав нь Сум хөгжүүлэх сангаас 2016 оны 04 сарын 28-ны өдөр “Хадлан бэлтгэл” тариалах зориулалтаар 15.000.000 / арван таван сая/ төгрөгийн зээлийг авсан.

2018 оны 04 сарын 28-ны өдөр зээлийн хугацаа дууссан бөгөөд иргэн С.Шарав үндсэн зээлийн үлдэгдэл төлбөр 9.729.385 төгрөгийг төлөөгүй байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

1.Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үлдэгдлийг баталгаажуулж байгаа бөгөөд хугацаа хэтрэлттэй иргэдтэй уулзаж 3 сая төгрөг төлүүлсэн.

2. Ажил хайгчийн программд түр ажлын байранд 10 иргэн, Шинэ ажлын байранд 4 иргэн бүртгэсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

1. Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийж, асаргаа сунгуулах 4 иргэний материалыг, Мөн рашаан сувилал, ахмадын амралт болон шүдний 13 материалуудыг бүрэн шийдвэрлэсэн.

3. 10 сарын хүнсний эрхийн бичгийг Шинэ дэлгүүрээр шинэ программаар олгож эхлээд 10 өрх аваад байна.

4. Шинээр төрсөн 1 хүүхдийн өргөдлийг хүлээн авч программд бүртгүүлсэн.

5.Цалинтай аав хөтөлбөрт 10 иргэн хамрагдсан.

6. Халамжийн шугамын дагуу 10 ахмад настанд харааны нүдний шил хийлгэсэн. Мөн Ахмадын баярыг тохиолдуулан харъяалалгүй 247 ахмадад хүндэтгэл үзүүлсэн. **Нийгмийн даатгалын чиглэлээр:**

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 540968,9 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ.

Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -473440,3 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 54650,3 мян төг
- ЭМДаатгалын шимтгэлд- 12878,3 мян төг орлоо.

Хэлтсээс 1145000.0 мян төгрөгийн санхүүжилт авч 450 тэтгэвэр авагчдад 164495,9 мян төгрөгийн тэтгэвэрийг олголоо.

СДДаатгалд 168 даатгуулагчидтай шинээр гэрээ байгууллан 54650,3 мян төгрөгийн шимтгэл , Эрүүл мэндийн даатгалд 176 даатгуулагчийг даатгаж 12878,3 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Шинээр өндөр насны тэтгэвэр -32, тахир дутуугийн тэтгэвэр-5, тэжээгчээ алдсаны тэтгэвэр -2 нийт 36 тэтгэврийг тогтоож, 6 тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн, 11 даатгуулагчдад ажилгүйдлын тэтгэмж тогтоон олгоод байна.

Оршуулгын тэтгэмж 20 тэтгэвэр авагчдад 20000.0 мян төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжинд 26 даатгуулагчдад 44104,6 мян, Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 5 даатгуулагчдад 329,9 мян төгрөгийн тэтгэмжийг тус тус олголоо.

Нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаандаа төлөөгүй 2 аж ахуй нэгжид албан шаардлага хүргүүлж 130000,0мян төгрөгийн шимтшэлийн өр авлагыг барагдуулж 130000,0мян төгрөгийн шимтшэлийн өр авлагыг барагдуулсан.

2020 оны харилцах, тооцооны хуудас тайлан, зогсоогдсон тэтгэврийн хувийн хэргийг архивлан нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгөв.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох өргөдөл-38 ,тэтгэвэр авах зөвшөөрөл-5, Банк солих-5 , тэтгэмж-43, ажилгүйдлын тэтгэмж-11 малчнаар ажилласан жил тогтоолгох-10 нийт 112 өргөдлийг хүлээн авч бүрэн барагдуулж , 806 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна.

Нийгмийн бодлогын чиглэлээр:

Ковид 19 өвчний батлагдсан тохиолдлын түргэвчилсэн мэдээг тухай бүр өгч байна. Угийн бичгээ хөтөлж, удмын сангаа хамгаалъя сэдэвт угийн бичиг хөтлөх уралдааны удирдамжийг гарган олон нийтэд мэдээллэсэн. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар мэдээллийг бэлтгэн иргэд олон нийтэд хүргэж байна.

Ерөнхий боловсролын сургууль :

- Аймгийн 2021 оны “Хөгжлийн хөтөч” удирдах ажилтнаар сургалтын менежер Д.Уугансүрэн шалгарлаа.
- Дэлхийн багш нарын 27 дахь, монголын багш нарын 55 дахь өдрөөр багш Х.Оюунтуяа, Н.Одончимэг, Ж.Нэргүй нар “Боловсролын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, Л.Мөнхтуяа, Ж.Мөнхсайхан нар БШУЯ-ны “Жуух бичиг”, Г.Тунгалаг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”, ахмад ажилчин Г.Нарангэрэл, Б.Туяа, ажилчин Ж.Энхбаатар, багш Э.Шинэтуяа, Э.Баасан нар аймгийн Засаг даргын “Баярын бичиг”ээр тус тус шагнагдлаа.
- БШУЯ-наас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төсийн хүрээнд 4,3000,000 /дөрвөн сая гурван зуун мянга/ төгрөгийн санхүүжилт бүхий “Математикт дурлаж массаараа хөгжье” тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжиж эхэллээ.
- Онцгой байдлын газраас гамшгаас хамгаалах өдрийн хүрээнд “Зөвхөн хамтдаа... Бид эх дэлхийгээ аварч чадна” уриан дор ахлах ангийн сурагчдад цахим сургалтыг зохион байгуулав.
- Дэлхийн багш нарын 27 дахь, монголын багш нарын 55 дахь өдрийн угтан сурагчдын дунд “Багшаа дуулъя” дууны уралдаан, “Багшдаа” шүлэг зохиох уралдааныг цахимаар зохион байгуулахад 6-9 дүгээр ангийн нийт 41 хүүхэд оролцов.
- ХИС-аас Японы жүжигчин Дийн Фужиокагийн цуглуулсан хандиваар хэрэгжүүлж буй зурагтай ном төслийн сургалтад захирал, сургалтын менежер нар хамрагдлаа.
- Эцэг эхийн хандив болон сургуулийн захиргааны тусламжтайгаар дотуур байрын 1,2 дугаар давхрыг хулдааслаж, өрөө тасгуудыг тохижуулав.

- “Өвсний үндэс” буцалтгүй тусламжийн хөтөлбөрт хичээлийн “Б” байрны их засварыг шийдвэрлүүлэх талаар хүсэлт явуулсны дагуу хөтөлбөрийн ажилтан Кида Эми ирж газар дээр нь үзэж танилцлаа.
- Шинээр ашиглалтад орсон 75 хүүхдийн дотуур байр руу сургуулийн харьяа гүний худгаас цэвэр усны шугам татав.

Хүүхдийн цэцэрлэг:

1. Ахмадын баярыг тохиолдуулан өөрийн цэцэрлэгийн ахмад багш нар болон 70 дээш насны 11 ахмадуудад гарын бэлэг гардууллаа.
2. Мэдээлийн системд цэцэрлэгийн нийт хүүхэд, багш, ажилчдын мэдээллийг шивж орууллаа.
3. Японы Хүүхдийг ивээх сангийн “Зурагт ном” төслийн сургалтанд 10 сарын 19-ний өдөр хамрагдлаа.
4. Японы Хүүхдийг ивээх сангийн “Зурагт ном” төслийн хүрээнд 157ш ном, 12 төрлийн ном тоглоомын багцын хүлээн авлаа.
5. Байгууллагын болон сумын цахим хуудсанд багш нар халдварт өвчнөөс сэргийлэх зөвлөмж, зөвлөгөө уриалгыг тогтмол байршуулан ажиллаж байна.
6. Багш ажилчдын дархлааг дэмжиж 506.000 мянган төгрөгний үнэ бүхий витаминжуулалтыг хийлээ.
7. Хүүхдийн дархлааг дэмжин өдөр бүр витаминжуулалт хийж байна. \Витамин С\
8. Өглөөний хүлээн авалт, таралтыг бөөгнөрөл үүсгэхгүйгээр зохион байгуулж, хүүхэд бүрт тандалт судалгаа хийж ажиллаж байна.
9. Цэцэрлэгийн хэмжээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж хэвшээд байна.
10. Аймгийн БСГ болон бусад албан газруудаас шаардсан бичиг тоотуудыг цаг хугацаанд нь өгч байна.

Соёлын төв:

Номын сан нь тайлант хугацаанд 12 иргэнд карт шинээр нээж 21 номыг гэрээр олгох үйлчилгээ үзүүлсэн.Цахим хуудсаараа дамжуулан танин мэдэхүйн мэдээлэл 3 оруулж :529 хүний хандалт авсан байна.Мөн зохиолч Д.Мөнхбаатарын зохиол “Нүүдлийн хөх тойрог” туужийг цувралаар уншигчдадаа хүргэж байна. Нийтдээ 1800 гаруй хүний хандалт авсан. Аймгийн нийтийн номын сангаас зарласан “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн” шалгаруулах уралдаанд уншигч хүүхдүүдээ бэлтгэж байна.шинэ соёлын төвийн барилга ашиглалтанд орох гэж байгаатай холбогдуулан шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл эд хөрөнгийн судалгааг гаргаж Соёлын яаманд хүсэлт хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн Газрын 257 тогтоол аймаг сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх сумын хэмжээнд угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлэх зорилгоор ЗДТГ-тай хамтран “УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛЖ -УДМЫН САНГАА ХАМГААЛЪЯ” сэдэвт угийн бичиг хөтлөх уралдааныг албан байгууллага ард иргэдийн дунд зарлаад байна.

Мөн “Угийн бичиг хөтлөх аргачлал” сургалыг зохион байгуулж байна.Хүүхдийн цэцэрлэгийн хамт олонд ажлын байран дээр нь очиж сургалтыг нийт ажилчдад онолын болон практик хэлбэрээр зохион байгууллаа.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа.

1. Сумын ГХЗУССалбар зөвлөлийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг гүйцэтгэж хамтран ажиллаа. Үүнд:
 - 1.1. “Насанд хүрээгүй хүүхдүүдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах” ажлын чиглэлээр 2021 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр “Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 8.1 дэх хэсэгт заасан сургуулийн сурагч, 18 нас хүрээгүй иргэнд согтууруулах ундаа хэрэглэх боломж олгохыг хориглосон байдаг” талаар ЗДТГ-н албан ёсны цахим хуудаснаас бичлэг нийтлэхэд бичлэгийг 275 хүн үзсэн, нийт 678 иргэнд хүрсэн байна.
 - 1.2. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчилж, зорилтот бүлгүүд болон хүчирхийлэл үйлдэгчдэд сургалт, сурталчилгаа явуулах” чиглэлээр 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр тус хуулийн тухай ЗДТГ-н албан ёсны цахим хуудаснаас бичлэг нийтлэхэд бичлэгийг 181 хүн үзсэн, нийт 481 хүнд хүрсэн байна. Мөн 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдөр тус хуулийн тухай бичлэг нийтлэхэд бичлэгийг 363 хүн үзсэн, нийт 741 иргэнд хүрсэн байна.
 - 1.3. “Архи, тамхи татгалзах, түүний хор хөнөөллийн талаар сургалт сурталчилгааг тогтмол иргэдэд хүргэх, мэдээллийн самбар, цахим хаяг байршуулах” чиглэлээр 2021 оны 09 дүгээр сарын 30, 10 дугаар сарын 06-ны өдөр “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль-”ийг хэрэгжүүлж, түүний хор уршгийг иргэд, олон нийтэд ойлгуулан таниулах зорилгоор мэдээлэл нийтлэхэд 1845 хүнд хүрсэн байна. Тамхины хор хөнөөллийн талаар 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Тамхины хор уршгийн талаар бичлэг нийтлэхэд бичлэгийг 194 хүн үзсэн, нийт 471 хүнд хүрсэн байна. 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдөр “Тамхины хор уршгийн тухай” бичлэг нийтлэхэд бичлэгийг 375 хүн үзсэн, нийт 955 хүнд хүрсэн байна. Мөн 2021 оны 10 дугаар сарын 7, 12-ны өдөр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс санаачлан гаргасан “Тамхинаас гарах шалтгаан №46, 47, 49” мэдээллийг нийтлэхэд нийт 3385 хүнд хүрсэн байна.
2. Сумын Цагдаагийн хэсэгтэй хамтран “Ятгах тусам нягтал” аяны хүрээнд 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийг хүртэл нийт 12 удаагийн давтамжтайгаар 10452 хүнд мэдээлэл, сурталчилгааг ЗДТГ-н албан ёсны цахим хуудаснаас хүргэсэн байна.
3. Орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээг 2021 оны 10 дугаар сарын 02-ны өдөр “Уулбаян сумын Засаг даргын Тамгын газар” гэсэн албан ёсны цахим хуудаснаас нийтлэхэд 1668 хүнд хүрсэн байна.

2021 онд шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар иргэдэд мэдээлэл, сурталчилгаа зохион байгуулах ажлын хүрээнд 17 хуулийн мэдээллийг хүснэгтлэн ЗДТГ-н албан ёсны цахим хуудаснаас нийтлэхэд 1085 хүнд хүрсэн байна.

Газрын тухай хуульд заасан газар ашиглагчийн эрх, үүргүүдийг багцлан 2021 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр мэдээлэл хүргэхэд нийт 4196 хүнд хүрсэн байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн талаар төсөвт байгууллагын архивын ажилтанд мэдээлэл хүргэсэн ба архив, бичиг хэргийн сургалтад хамруулан ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А/139 дүгээр захирамжаар сумын хэмжээнд 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хүртэл 10 хоногийн хэсэгчилсэн хорио цээрийн дэглэм тогтоосон.

Иргэдээс ирүүлэх өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээллийг хүлээн авах 98514040 дугаар ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А/140 дүгээр захирамж гарган коронавируст халдварын тархалтыг хумих, өвчтөний ойрын болон дам хавьтлыг илрүүлэх ажлыг эрчимжүүлэхээр 8 гишүүнтэй “Тандалтын бүлэг” байгуулж, Эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллаж, аймгийн Онцгой Комисст шаардлагатай мэдээ, тайланг тогтмол хүргүүлж байна.

Авлигатай тэмцэх газраас төрийн албанд шинээр томилогдсон албан тушаалтнуудад зориулан 2021 оны 10 дугаар сарын 01-ны өдөр зохион байгуулсан “Авлигын эсрэг” сургалтад төрийн байгууллагын 5 албан тушаалтанд хамрагдсан.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.ДАШБАЛЖИННЯМ